

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан танхимын сургалтын хөтөлбөр


УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын болон нийслэл, дүүрэг дэх Улсын бүртгэлийн газар, хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан улсын бүртгэгчдийн ажлын бүтээмжийг дээшлүүлэх, тэднийг чадавхжуулах, бүртгэл хөтлөх болон цахим системийн боловсруулалтад анхаарах асуудлуудын талаар зөвлөмж, чиглэл өгөх сургалтыг өнөөдөр /2020.10.31/ зохион байгууллаа.



Байгууллагын ажиллагсдын хувь хүний зохион байгуулалт, хөгжлийн асуудал болон үйлчилгээний хугацаанд тулгамдаж буй нөхцөл байдал, ур чадварын талаар ОУУБИС-ийн эрдэм шинжилгээний албаны дарга, доктор, дэд профессор О.Бурмаа хичээл зааж, сургалтыг эхлүүллээ. Тэрбээр, харилцааг амжилттай болгоход хэрэглэх зарим техник болон үйлчилгээний харилцааны тулгамдаж байгаа асуудал, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх тухай голлон ярьж сонирхолтой жишээнүүд дээр тайлбарлан хүргэсэн юм.



Үргэлжлүүлэн “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвийн хүрээнд НУБГ-ын Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Х.Батгэрэл, “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг” сэдвийн хүрээнд АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар А.Цэдэн-Иш, “Нотариатчаас нийлүүлсэн мэдээллийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх нь” сэдвийн хүрээнд ЭХЭУБГ-ын дарга Б.Ариунболд, “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх заавар” сэдвээр ЭХЭУБГ-ын улсын ахлах бүртгэгч Ө.Өнөрлхам нар тус тус мэдээлэл хүргэж, оролцогчдын сонирхсон асуулт, хариултаар сургалт өндөрлөлөө.





Сонордуулахад, УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас нийт 60 орчим төрлийн үйлчилгээ үзүүлж байгаагийн 50-60 хувийг барьцааны гэрээ шинээр бүртгэх болон дуусгавар болгох үйлчилгээ эзэлдэг байна. Улсын хэмжээнд нийт 179

эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч ажиллаж байгаагаас 76 албан хаагч нь нийслэлд, 92 нь орон нутагт, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт 11 албан хаагч тус тус ажиллаж байна.



Өнөөдрийн сургалтыг УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд удирдаж, Тамгын газрын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтэс болон Азийн хөгжлийн банкны төслийн багийнхан хамтран зохион байгууллаа **гэж УБЕГ-ын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсээс мэдээлэв.**